



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/263

Номгон

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн  
салбар зөвлөл байгуулах тухай

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах шаардлагатай болсныг тэмдэглэн: “Монгол хэлний тухай хуул”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн “Салбар зөвлөл байгуулах тухай” 03 дугаар тогтоолын 1.3, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Баянхонгор аймгийн салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Гишүүд: Д.Чулуунцэцэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол хариуцсан мэргэжилтэн

Д.Отгонжаргал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн Хүний нөөц, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

О.Дашдаваа - Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Боловсрол, соёл урлаг хариуцсан мэргэжилтэн

Б.Бямбачимэг - Ерөнхий боловсролын лаборатори “Номундалай” цогцолбор сургуулийн монгол хэл бичгийн багш

Б.Даваадолжин - Ерөнхий боловсролын Эрдэнэмандал ахлах сургуулийн монгол хэл, бичгийн багш

С.Үнэнбуян - Хэл, соёлоо эрхэмлэгч иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Одгэрэл: Боловсрол, соёл урлагийн газрын Монгол хэл, уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтэн


2. Монгол хэлний тухай хууль, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж сумын Засаг даргаар ахлуулсан салбар зөвлөл байгуулж, ажлын төлөвлөгөө батлан, хэрэгжилтийн тайланг аймгийн “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөл”-д ирүүлж байхыг сумын Засаг дарга нарт, Монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

821010557

2.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр )-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН